Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 05/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нь Орон нутагтаа бүх шатны Хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баяндэлгэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Тус байгууллага мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Баяндэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр байгуулсан дотоод хяналтын 3-н гишүүнтэй ажлын хэсэг ажиллаж байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна.

Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяндэлгэр сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагыг суурь үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 22,520.6 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80,0 хувиар буюу 18,016.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагатай байна

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагаас 1,5 хувиар буюу 30,837.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 8,317.4 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 24,670.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, эм эргэлтийн сан, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем программыг ашиглаж байна.

***Орлогын талаар:***

Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 665,326.9 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилт 889,964.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 8,067.7 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн сангийн санхүүжилт 89,462.7 мянган төгрөг, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 144,940.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн орлого 67,538.9 мянган төгрөг, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн 500.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 176,534.2 мянган төгрөг, эрүүл мэндийн төвийн орлого 77.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлого 201,117.1 мянган төгрөг, нийт 2,243,529.6 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг мөнгөн гүйлгээний тайлангаар төвлөрүүлэн зарцуулсан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлогыг хоорондын тооцоогоор устгал хийсэн байна.

Баяндэлгэр сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 10 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 56,962.1 мянган төгрөг, татварын бус орлогыг 7,400.0 мянган төгрөг, нийт 64,362.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 172,578.7 мянган төгрөг, татварын бус орлого 28,538.3 мянган төгрөг буюу 312,5 хувиар давуулан биелүүлсэн байна. Энэ нь малын тоон толгойн албан татвар шинээр мөрдөж эхэлсэнтэйгээр 59,162.7 мянган төгрөг, ан агнах тусгай зөвшөөрөл, гэрээний дагуу ан агнуурын нөөц ашигласан төлбөрт 57,358.9 мянган төгрөг төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 6,798.4 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 218,920.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор, нийт 225,718.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 70,775.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 251,700.5 мянган төгрөгийн, хандив, бусад эх үүсвэрээр 116,074.6 мянган төгрөгийн, нийт 367,775.2 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 358,236.8 мянган төгрөгийн бараа материалыг данснаас хассан байна

***Авлага, өглөгийн талаар*:**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд ажиллагчидтай холбогдсон авлага 1,025.0 мянган төгрөг, байгууллагаас авах 98,098.7 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах 319,041.5 мянган төгрөг, нийт 418,165.2 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн. Үүнд: ЗДТГ нь ажиллагчидтай холбогдсон 1,025.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй ба байгууллагаас авах авлага нь ОНХС-ийн 40,745.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн 57,353.0 мянган төгрөг, Хувь хүмүүсээс авах авлага нь сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 307,491.2 мянган төгрөг, эм эргэлтийн сангийн авлага 11,226.1 мянган төгрөг, ЕБС-ийн авлага 324.2 мянган төгрөг байна.

Өглөгийн үлдэгдлээр байгалийн нөхөн сэргэлтийн барьцаа сангийн өглөг 1,100.0 мянган төгрөг, байгууллага, хувь хүмүүсийн өглөг 19,116.3 мянган төгрөг, нийт 20,216.3 мянган төгрөг нэгтгэгдсэн байна. Үүнд: байгууллагад өгөх өглөгийн 10,746.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн төвийн, 8,160.7 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн өглөг эзэлж байна.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 494,091.1 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд эмийн эргэлтийн сангийн 29.1 мянган төгрөг, нийт 494,120.2 мянган төгрөгийн мөнгөн

хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Төрийн сангийн харилцах дансанд орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 248,480.0 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 171,878.1 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 55,324.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн төвийн үлдэгдэл 10,261.5 мянган төгрөг, байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн 8,150.0 мянган төгрөг байршиж байна.

Бараа материал 237,103.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 2,925,080.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 306,456.3 | 494,120.2 | 187,663.9 |
| **Авлага** | 346,997.2 | 418,165.3 | 71,168.1 |
| **Урьдчилгаа** | 0 | 0 | |
| **Бараа материал** | 227,565.0 | 237,103.3 | 9,538.3 |
| **Үндсэн хөрөнгө** | 2,886,995.0 | 2,925,080.3 | 38,085.4 |
| **Нийт хөрөнгө** | 3,768,013.5 | 4,074,469.1 | 306,455.6 |
| **Өр төлбөр** | 1,155.9 | 20,216.3 | 19,060.4 |
| **Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/** | 3,766,857.5 | 4,054,252.7 | 287,395.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3,768,013.5 | 4,074,469.1 | 306,455.6 |

Бараа материалын дансны үлдэгдэл 237,103.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 9,538.3 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материалын үлдэгдэл 4,481.2 мянган төгрөг, бусад материалын үлдэгдэл 11,612.4 мянган төгрөг, хүнсний материал 3,302.2 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,925,080.3 мянган төгрөг болж 38,085.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 225,718.5 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,054,252.7 мянган төгрөг болж 287,395.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд хүргүүлсэн саналыг шилэн дансны цахим хуудсанд байршуулж, мэдээлээгүй, аудитын явцад төсвийн төслийн талаарх мэдээлэл ирүүлээгүй болно.

Баяндэлгэр сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 10 дугаар тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 56,962.1 мянган төгрөг, татварын бус орлогыг 7,400.0 мянган төгрөг, нийт 64,362.1 мянган төгрөгөөр, 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,853,470.7 мянган төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 153,524.0 мянган төгрөгөөр тус тус баталсан.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дүгээр сарын 17-ны өдрийн 23 дугаар тогтоолоор 2,090,978.5 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 1,556,522.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 101,501.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 139,268.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,059,598.5 мянган төгрөг төсөвлөгдсөн. Энэ нь сумын ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнөөс 21,004.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Тайлант оны зардлын 1,154,836.3 мянган төгрөгийг Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, 1,898,052.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн санхүүжилт, 20,848.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, 90,865.5 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангийн санхүүжилт, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 100,000.0 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,556,523.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 101,501.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 139,268.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 1,797,292.4 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 18,016.9 мянган төгрөгийг аймгийн төсөвт, 43,003.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,797,292.5 мянган төгрөг буюу 85,9 хувьтай хэрэгжсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 176,534.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 108,791.4 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 29,877.3 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 37,865.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Баяндэлгэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн харьяа байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторууд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт өгч, 217,297.7 мянган төгрөгийн залруулга хийгдэж, 11,315.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 107,738.2 мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөн. ОНХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 11,148.4 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Уваа-Уул Аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, эмийн эргэлтийн сан гэсэн 4 санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан.

Аудитаар ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт өгч, ЕБС-ийн санхүүгийн тайланд 87,503.7 мянган төгрөгийн 3 зөвлөмж, СӨБ-ийн санхүүгийн тайланд 25,386.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд 148,826.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Баяндэлгэр Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугээр сарын 17-ны өдрийн 23 дугаар тогтоолоор 2,090,978.5 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөг 2,092,461.1 мянган төгрөг буюу 1,482.6 мянган төгрөгөөр ОНХС-ийн төлөвлөгөө зөрүүтэй байна.

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг Татварын албанаас гаргуулан цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад сумын ИТХ нь цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 418.6 мянган төгрөгөөр дутуу, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 26.0 мянган төгрөгөөр илүү, ЗДТГ нь цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 1,317.4 мянган төгрөгөөр дутуу, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 13,634.3 мянган төгрөгөөр илүү, Соёлын төв 204.1 мянган төгрөг илүү, ЕБС 162.2 мянган төгрөг илүү байна. Орон нутгийн татварын орлогыг тооцооллыг тухай бүрд хийдэггүйгээс аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтоор татварын орлогын үлдэгдэл зөрүүтэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 152 мэдээллээс хугацаа хоцроосон 37, огт байршуулаагүй 23 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа байршуулсан ногоон төлөвтэй мэдээллүүд нь шаардлагад бүрэн нийцэхгүй, дутуу, хоосон, байхгүй гэх зэргээр байршуулсан. Тухайлбал: Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 1-12 дугаар сард байхгүй гэж мэдээлсэн, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт аудитын тайлан, санал дүгнэлт акт албан шаардлагыг буруу байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 05/271 дугаар албан бичгээр ирүүлсэн. Өмнөх аудитаар өгөгдсөн шилэн дансны мэдээллийг үнэн зөв гүйцэд байршуулах гэсэн зөвлөмж давтагдаж байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баяндэлгэр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна. Аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын дагуу сумын хэмжээнд нэгдсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 125,976.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21,967.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,591.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 45,036.2 мянган төгрөгийн албан шаардлага, 52,380.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Сумын соёлын төвийн санхүүгийн тайланд өмнөх оны үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнаснаас Санхүүгийн үр дүнгийн тайланд нийт үр дүнг 13,916.8 мянган төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний тайланд нийт цэвэр мөнгөн гүйлгээг 3,505.8 мянган төгрөгөөр, нийт 17,422.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд өмнөх оны үзүүлэлтүүдийн мэдээллийг хянаагүйгээс Санхүүгийн үр дүнгийн тайланд нийт үр дүнг 1,438.7 мянган төгрөгөөр, Мөнгөн гүйлгээний тайланд нийт цэвэр мөнгөн гүйлгээг 2,455.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан. Төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлант оны батлагдсан төлөвлөгөөг 200.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. Санхүү байдлын тайланд болон Мөнгөн гүйлгээний тайланд 450.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан нь үлдэгдлийн баталгаагаар үлдэгдэлгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар

зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

**4.2 Төлбөрийн акт**

Баяндэлгэр сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн "Мөнгөн шагнал олгох тухай" Б/29 дүгээр тушаалаар байгууллагын дарга эрхлэгчид 1.5 сар буюу 1,211.4 мянган төгрөгийн, Соёлын төвийн эрхлэгчийн мөн өдрийн Б/11 дүгээр тушаалаар 1 албан тушаалтанд үндсэн цалингийн 70% буюу 964.8 мянган төгрөгийн, нийт 2,176.2 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.3-д "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Соёлын төвийн эрхлэгчийн 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн "Төсөв зарцуулах тухай" А/07 дугаар тушаалаар 190.6 мянган төгрөгийг айраг, архи, хүнс материал авахад зарцуулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5.-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Сумын ИТХТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 58 дугаар тогтоолоор ИТХ-ын даргад 0.5 сарын буюу 362.9 мянган төгрөг, ИТХ-ын нарийн бичгийн даргад 522.8 мянган төгрөгийн мөнгөн шагналыг цалингийн сангаас олгосон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д

“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.3-д “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг төсвийн байгууллага жил бүр төсөвтөө тусгана” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

Газар эзэмших, ашиглах эрх шилжилтийн судалгааг газрын даамлаар гаргуулан хувь хүний орлогын албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлсэн эсэхийг тулгахад 3,338.9 мянган төгрөгийн татварын орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д ”аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-д “газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого”, 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна” гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтоох гэсэн дагуу шийдвэрлэв.

### 4.3 Албан шаардлага

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзэхэд суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 9,645.1 мянган төгрөгөөр буюу 77,2 хувиар, Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 1,252.0 мянган төгрөг буюу 9,6 хувиар, газрын төлбөр 3,160.5 мянган төгрөг буюу 38,1 хувиар, бууны албан татвар 60.0 мянган төгрөгөөр буюу 6,2 хувиар нийт 4 нэр төрлийн орлого 14,117.6 мянган төгрөгөөр тасарсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “төсвийн орлого, зарлагыг буруу

тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 30,918.6 мянган төгрөгийн хугацаа хэтрэлттэй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. *Татварын орлогын мэдээтэй холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Орон нутгийн орлого 201,117.0 мянган төгрөгийг аймгийн Татварын хэлтсийн мэдээгээр 208,207.9 мянган төгрөг буюу 7,090.9 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн. Татварын байцаагч нь түрээсийн орлогоор төвлөрсөн 5,070.0 мянган төгрөгийн орлогыг татварын мэдээнд 9,031.4 мянган төгрөгөөр илүү, төсөвт газрын өөрийн орлогоор 550.0 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 9,091.4 мянган төгрөгийг нэр зааж ангилаагүй орлогоор, нийт 25,763.7 мянган төгрөгийг зөрүүтэй мэдээлж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Татварын болон татварын бус орлогын ангилал, тоон мэдээллийг үнэн зөв баталгаажуулж, орлогын мэдээ тайланг санхүүгийн үндсэн баримтад тулгуурлан нэр төрлөөр болон үнийн дүнг зөв ангилан мэдээлж хэвших

**2. *Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 10,854.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд

заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

### 3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

*3.1. Илрүүлэлт:*

Тайлант онд мэдээлбэл зохих 152 мэдээллээс 39,5 хувь буюу 37 мэдээллийг хугацаа хоцроосон, 23 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Шилэн дансны цахим хуудсанд хугацаандаа байршуулсан ногоон төлөвтэй мэдээллүүд нь шаардлагад бүрэн нийцэхгүй, дутуу, хоосон, байхгүй гэх зэргээр байршуулсан байна. Тухайлбал: Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 1-12 дугаар сард байхгүй гэж мэдээлсэн, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт аудитын тайлан, санал дүгнэлт акт албан шаардлагыг буруу байршуулсан. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам", санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, иж бүрэн мэдээлэх

### 4. Татварын мэдээлэлтэй холбоотой асуудал

*4.1. Илрүүлэлт:*

Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолтыг үндэслэн цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын тооцооллыг тулгахад сумын ИТХ нь цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 418.6 мянган төгрөгөөр дутуу, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 26.0 мянган төгрөгөөр илүү, ЗДТГ нь цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар 1,317.4 мянган төгрөгөөр дутуу, Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 13,634.3 мянган төгрөгөөр илүү, Соёлын төв 204.1 мянган төгрөг илүү, ЕБС 162.2 мянган төгрөгөөр илүү, Цэцэрлэг мэдээллээ ирүүлээгүй ба нийт 15,762.6 мянган төгрөг зөрүүтэй үлдэгдэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5.-д "хариуцлагатай байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Аж ахуйн нэгж байгууллагын албан татварын тооцоог тухай бүрд хийж, мэдээ тайланг үнэн зөв баталгаажуулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Засаг дарга | 12 | 125,976.2 | 2 | 21,967.8 | 4 | 6,591.4 | 2 | 45,036.2 | 4 | 52,380.8 |
| 2 | ЗДТГ | 11 | 336,350.9 | 3 | 217,297.7 | 4 | 11,315.0 | 3 | 107,738.2 | 1 | 0 |
| 3 | ЕБС | 3 | 87,503.7 | | | | | | | 3 | 87,503.7 |
| 4 | ЭМТ | 4 | 142,826.3 | 1 | 142,826.3 | | | 1 | 0 | 2 | 0 |
| 5 | СӨБ | 3 | 25,386.6 | | | | | | | 3 | 25,386.6 |
| 6 | Нийт дүн | 33 | 718,043.7 | 6 | 382,091.8 | 8 | 17,906.4 | 6 | 152,774.4 | 13 | 165,271.1 |